

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 09

Тус газар нь нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, өр авлагыг барагдуулах, нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь тогтоож олгох, ажил олгогч, даатгуулагч иргэдэд хөнгөн шуурхай чирэгдэлгүй үйлчлэх, дотоодын хяналт шалгалтын ажлыг эрчимжүүлэн үр дүнг дээшлүүлэх, мэдээллийн систем хөгжүүлэх төслийн хүрээнд ажилтан, албан хаагчдыг сургах, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах зэрэг ажлыг хэрэгжүүлж, Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагын хэмжээнд 2025 оныг “Даатгуулагчийг дэмжих, нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах жил”, дүүргээс “Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан хийх ажлын төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх хүрээнд ажил, үйлчилгээгээ төлөвлөн хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтын талаар

2025 оны 11 сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын 3 674,4 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс нийгмийн даатгалын санд 3 907,8 сая төгрөгийг хуримтлуулж орлогын төлөвлөгөө 106,0 хувиар биелүүлсэн ба 12 дугаар сарын хүлээгдэж буй гүйцэтгэлээр 460,8 сая төгрөгийн орлого бүрдүүлж 105 хувиар биелэхээр байна.

Нийгмийн даатгалын тухай хуулиар даатгуулагчдад:

- Тэтгэврийн даатгалын сангаас 8.8 тэрбум төгрөг
- Тэтгэмжийн даатгалын сангаас 489.1 сая төгрөг
- ҮОМШӨ-ний даатгалын сангаас 68.7 сая төгрөг
- Ажилгүйдлийн даатгалын сангаас 233.5 сая төгрөг

Нийт 9.7 тэрбум төгрөгийн батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөр зардлыг хугацаанд нь олгосон байна.

Тайлант хугацаанд нийт 725 тэтгэвэр авагчдад 7 745.6 сая төгрөгийг зарцуулсан. Төрөлжүүлбэл:

- Өндөр насны тэтгэвэр- 5 994.1 сая төгрөг,
- Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр- 569.4 сая төгрөг,
- Тэжээгчээ алдсаны тэтгэвэр- 212.7 сая төгрөг,
- Цэргийн алба хаагчийн тэтгэвэр- 966.0 сая төгрөг,

Мөн Нийгмийн даатгалын тэтгэмжийн даатгалын сангаас 280 даатгуулагчид 489.1 сая төгрөгийг зарцуулсан. Төрөлжүүлбэл:

- Хөдөлмөрийн чадвар түр алдсны тэтгэмж- 20.0 сая төгрөг
- Жирэмсний болон амаржсаны тэтгэмж- 398.7 сая төгрөг
- Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж- 30.0 сая төгрөг

Сангийн төвлөрүүлэлт, хуваарилалтын талаар:

Нийт 4.4 тэрбум төгрөгийн НДШ-ийн орлогыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар НДШ орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журмын 3 дугаар зүйлийн 3.3-д заасны дагуу төвлөрсөн харилцах дансны үлдэгдлийг өдөр бүр төв санд төвлөрүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Тэтгэмжийн даатгалын санд 371.3 сая төгрөг
- ҮОМШӨ даатгалын сан 215 сая төгрөг
- Ажилгүйдлийн даатгалын сан 136.5 сая төгрөг

Нийгмийн даатгалын сангаас даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж бусад зардлыг сан тус бүрээр, аж ахуйн нэгж байгууллагуудад үйл ажиллагааны зардлыг шилжүүлэхийн өмнө батлагдсан төсөв хүрэлцээтэй эсэхийг хянан баталгаажуулж зарлагын гүйлгээ хийж байна.

Нийгмийн даатгалын хамралт, өр авлага барагдуулалтын талаар:

Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, тушаал шийдвэр, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн тогтоол зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн сахилга хариуцлагыг дээшлүүлэн ажиллаж байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу хамралтыг нэмэгдүүлэхээр тус дүүргийн Татварын хэлтсээс ААНБ-ын судалгааг гаргуулан нийгмийн даатгалд хамруулах ажлыг зохион байгуулан ажилласнаар шинээр 5 ажил олгогчийг нийгмийн даатгалд хамруулсан. Үүнд:

1. 94 дүгээр сургууль
2. Насан туршийн суралцахуйн төв
3. Ян сарьдаг ХХК
4. Сарьдаг хангай оргил ХХК
5. Тэгш дөрвөн эрдэнэ ХХК зэрэг ажил олгогчийг хамруулаад байна.

Тайлант хугацаанд нийт 69 ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авч баталгаажуулан ажилласан. Зорилтот жилийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөө боловсруулан хамралтыг нэмэгдүүлэхээр малчид болон, шугам замын өрхөөр явуулын үйлчилгээгээр үйлчилж, сайн дурын даатгалд хамрагдахын ач холбогдлыг сурталчлан ажиллаж, сайн дурын даатгалд 84 даатгуулагч хамруулсан байна. Энэ нь өмнөх оны хамралтаас 40-өөр буурсан үзүүлэлттэй байна.

11 дүгээр сарын байдлаар:

- Ажил олгогч- 69
- Албан журмын даатгуулагч – 1350
- Сайн дурын даатгуулагч- 84 тус тус хамрууллаа.

Оны эхний 155,7 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагаас 37,1 сая төгрөгийг барагдуулсан бөгөөд 11 дүгээр сарын 30-ны байдлаар 257,0 сая төгрөгийн авлага үүсээд байна. Жилийн эцсийн байдлаар төсөвт байгууллага урсгал авлагыг барагдуулж, авлагын хэмжээг 100.0 сая төгрөг болгон бууруулахаар ажиллаж байна.

Төсөвт байгууллагуудаас боловсролын 5 байгууллага 64.8 сая төгрөг, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн 2 байгууллагын 27.9 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй бөгөөд удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, зарим ААНБ-д албан шаардлага хүргүүлэн авлагыг барагдуулахаар ажиллаж байна.

Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт, тооллогын талаар

Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хэсэгдэх хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгаж нэгдсэн судалгааны мэдээг ТӨХ/

Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” программд дараа оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор бүрэн мэдээлсэн.

Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын дагуу шилжүүлэх, актлах, ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэх хөрөнгийн элэгдлийг 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр урьдчилан үнэн зөв тооцож, хөрөнгийн элэгдлийг ирүүлэх тухай албан бичгийн дагуу 2025 оны сүүлийн хагас жилээр актлах хөрөнгө 31 ширхэг 16.4 сая төгрөг болон үнэ шинэчлэн тогтоох хөрөнгө 28 ширхэг 9.6 сая төгрөгийн жагсаалтыг холбогдох баримтын хамт Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт хүргүүлсэн.

Төрийн өмчийн эд хөрөнгийг бүртгэх, хувийн хэрэг хөтлөх, улсын бүртгэлд бүртгүүлэх, хөрөнгийн тооллого хийх, санхүүгийн болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим системд мэдээ, тайланг гаргах, холбогдох журмын дагуу тайлагнаж байна.

Мөн албан хаагч бүртэй эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулан, сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралт маягтаар хөрөнгө ашиглалтын бүртгэл хөтлөн ажиллаж байна.

**Төсөв, санхүү, мэдээллийн ил тод байдал, дотоодын болон
бусад хяналт шалгалтын талаар:**

Дотоодын хяналт шалгалт:

Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтыг мэдээллийн нэгдсэн сан, анхан шатны баримтад үндэслэн дотоодын хяналт шалгалтыг хийж, 9 тэтгэвэр авагчдад 125.1 сая төгрөгийг илүү олгосон зөрчлөөс 10.2 сая төгрөгийг барагдуулж, өмнөх оны үлдэгдэлтэй нийт 115.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөн 8 даатгуулагчдад 28.0 сая төгрөгийн ХЧТА, ажилгүйдлийн, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох тэтгэмийг илүү олгосон зөрчлөөс 8.7 сая төгрөгийг барагдуулж 19.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Актаар тогтоогдсон авлагыг барагдуулахаар зарим тэтгэвэр авагчидтай гэрээ байгуулж тэтгэврээс 50 хувийн суутгал хийж, зарим иргэдтэй гэрээ байгуулан төлөгдөж байна.

Бусад хяналт шалгалт:

Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтыг мэдээллийн нэгдсэн сан, анхан шатны баримтад үндэслэн дотоодын хяналт шалгалтыг хийж, 5 тэтгэвэр авагчдад 25.5 сая төгрөгийг илүү олгосон зөрчлөөс 6.8 сая төгрөгийг барагдуулж, өмнөх оны үлдэгдэлтэй нийт 20.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

НДЕГ-ын Хяналт шалгалтын газраас 2025 онд хийсэн хяналт шалгалтаар 2 даатгуулагчид 444.0 мянган төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон зөрчилд акт тавигдсан бөгөөд зөрчлийг бүрэн барагдуулсан.

Дотоодын хяналт шалгалтаар 1.2 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон зөрчил илэрсэн бөгөөд оны эхний үлдэгдлийн хамт 2.4 сая төгрөгийг барагдуулж 0.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтыг мэдээллийн нэгдсэн сан, анхан шатны баримтад үндэслэн дотоодын хяналт шалгалтыг хийж, 5 тэтгэвэр авагчдад 25.5 сая төгрөгийг илүү олгосон зөрчлөөс 6.8 сая төгрөгийг барагдуулж, өмнөх оны үлдэгдэлтэй нийт 20.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийгмийн даатгалын сан, санхүүгийн тайлангийн “Өлзийт экаунт аудит” ХХК-н санхүүгийн аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан бөгөөд акт, албан шаардлага байхгүй, 2 зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байна.

-Цахим дэлгүүрээс бараа материал, үндсэн хөрөнгө авах гэх зэрэг асуудлыг эхний хагас жилийн байдлаар мөрдөж ажиллаж байна.

Зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт, "Өлзийт экаунт аудит" ХХК-д хуулийн хугацаанд тайлагнасан.

2025 оны завсрын аудитыг Гэрэлтэх бүртгэл аудит ХХК-тай гурвалсан гэрээ байгуулан холбогдох санхүүгийн файл, анхан шатны баримтыг хүргүүлэн ажиллаж байна.

Төсөв санхүү:

2025 оны 11 дүгээр сарын байдлаар үндсэн үйл ажиллагааны зардалд- 289.7 сая төгрөгийн төсөв батлагдаж 273.1 сая төгрөгийг зарцуулснаас:

- Цалин хөлс түүнтэй адилтгах зардалд- 216.4 сая төгрөг
- Нийгмийн даатгалын шимтгэл- 27.5 сая төгрөг
- Байр ашиглалтын зардалд- 3.9 сая төгрөг
- Бараа материалын зардал- 6.2 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал- 7.5 сая төгрөг
- Хөдөө орон нутаг, бусад тусламж дэмжлэгийн зардал- 11.6 сая төгрөг тус тус зарцуулсан.

Мэдээллийн ил тод байдал:

2025 онд санхүүгийн нийт 171 төрлийн мэдээ мэдээллээс 2 мэдээллийг хугацаа хоцроосон, хүний нөөцийн нийт 60 мэдээ мэдээллэхээс 53 мэдээллийг хугацаанд нь мэдээллэсэн 1 мэдээллийг хугацаа хоцроосон ба мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.

Иргэд, даатгуулагчдад мэдээллийг ил тод нээлттэй хүргэхэд шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг шилэн дансны цахим системд (shilendans.gov.mn), мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангах цахим систем (shilen.gov.mn), байгууллагын фэйсбүүк хуудас (Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газар), веб хуудас (bagahangai.ndaatgal.mn), мэдээллийн самбар зэрэгт мэдээллэн ажиллаж байна.

2025 оны 11 дүгээр сарын байдлаар Bagahangai.ndaatgal.mn веб хуудсанд нийт 25 төрлийн мэдээллийн ил тод байдлыг ханган байршуулсан.

"Багахангай дүүргийн Нийгмийн даатгалын газар" пэйж хуудас нь 2025 оны 4 дүгээр сард шинээр нээгдсэн бөгөөд тус хуудсанд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой-20, Нийгмийн даатгалын ерөнхий газрын-35 мэдээллийг хуваалцан ажиллаж байна.

Ажил олгогч, даатгуулагчийн мэдээлэл нийгмийн даатгалын цахим системд үнэн зөв бүртгэгдсэн эсэхийг хянаж үзэхэд:

- Ажил олгогч-69
- Албан журмын даатгуулагч-1350
- Сайн дурын даатгуулагч- 84
- Сайн дурын даатгуулагч эх- 4 зэрэг мэдээллийг үнэн зөв бүртгэж олгосон.

Тайлант хугацаанд ажил олгогч болон сайн дурын даатгуулагчийн мэдээлэлд залруулга хийгдээгүй байна. Мөн

- Тэтгэвэр авагч- 725
- Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж- 113,
- Жирэмсэн амаржсаны тэтгэмж- 82,
- Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж- 15,

Нийт 1004 даатгуулагчийн мэдээллийг цахим системд үнэн зөв бүртгэсэн.

Иргэд, даатгуулагчдад мэдээлэл, зөвлөгөө өгсөн байдал:

2025 оны 11 дүгээр сарын байдлаар байгууллагын лавлах утас 7049-1151 (callpro) утсаар ирсэн дуудлага 208, дуудлага алдалт 10% байна. Иргэд, даатгуулагчдад утсаар зөвлөгөө мэдээллийг шуурхай өгч ажилласан байна.

Архив, албан хэрэг хөтлөлт, дотоод үйл ажиллагааны талаар

Албан хэрэг хөтлөлтийн ер цахим системээр 189, able программаар 266 албан бичиг ирснийг хүлээж авч бүртгэл хөтлөн газрын даргад танилцуулан хариутай 181 албан бичгийг холбогдох албан тушаалтнуудаар хугацаанд нь шийдвэрлүүлсэн ба бусад байгууллагуудад 171 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулан ажилласан.

Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлсэн иргэдэд нийгмийн даатгалын лавлагаа цахим мэдээллийн сангаас:

-QR кодтой- 50,

-Архивын цаасан баримтаас шүүж- 74

-Харьяа аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын хүсэлтийн дагуу- 17 лавлагааг гарган өгсөн.

Мөн иргэд даатгуулагчдын хүсэлтийг чирэгдэлгүй шуурхай үйлчилгээ үзүүлэх зорилгоор бусад аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрууд руу 17 хүсэлтийг дотоод сүлжээгээр дамжуулан лавлагааг авч даатгуулагчдын тэтгэврийг хугацаа алдалгүй тогтоосон.

2025 оны 11 дүгээр сарын байдлаар дээд газраас нийт 94 тогтоол шийдвэр ирсэн бөгөөд үүнээс:

-Монгол Улсын Засгийн газрын тогтоол- 2

-Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаал-2

-Монгол Улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын тушаал- 3

-Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын захирамж, тогтоол-2

-Нийслэлийн засаг даргын захирамж-2

-Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал- 57

-Багахангай дүүргийн Засаг даргын захирамж- 9

-Багахангай дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол – 2

-Бусад-15

Нийт ирсэн тогтоол шийдвэрийн 47.8 хувь буюу 45 нь хариутай бөгөөд биелэлтийг 100 хувь хугацаанд хүргүүлсэн ажилласан. Тогтоол шийдвэрийг хэрэгжилтийг ханган шийдвэрлэсэн дундаж хоног 3 байна. Бусад 49 тогтоол шийдвэрийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

2025 оны архивын улсын үзлэгт бэлтгэн архивын өрөөнд галын аюулгүй байдлын самбар, элс, хүрз, халаад, бээлий, маск, зэргээр хангаж архивын өрөөний тавиурыг сольж тохижуулсан. Архивын өрөөний чийг, дулааныг байнга хэмжиж байх температур хэмжигч багажийг Байгаль, орчин хэмжил зүйн лабораторид баталгаажуулалт хийлгэсэн бөгөөд уг улсын үзлэгт 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр хамрагдан 87.8 хувьтай үнэлэгдсэн байна.

Архивын төлөвлөгөөт нөхөн бүрдүүлэлтийн ажлыг бүрэн дуусгасан бөгөөд Дүүргийн Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 2 дугаар хурлаар

Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн -103 баримт

Түр хадгалах хадгаламжийн нэгжийн- 306 баримт

70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн- 131 баримт

Устгах- 31 баримтын жагсаалтын батлуулсан

Үүнээс байнга хадгалах хадгаламжийн нэгжийн 103 баримтыг төрийн архивт

Газрын даргын боловсон хүчний-17, үйл ажиллагаатай холбоотой-11 захирамжлалын баримт бичгийг хууль зүйн үндэслэлтэй боловсруулсан.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын талаар:

Газрын хэмжээнд тайлант хугацаанд байгууллага, иргэдээс 9 өргөдөл гомдлыг хүлээн авч холбогдох албан тушаалтнуудаар хугацаанд нь шийдвэрлүүлж, хариуг шуудангаар, албан бичгээр хүргүүлсэн. Үүнээс:

- Засгийн газрын өргөдөл хүлээн авах 1111 төвөөр 1 өргөдөл,
- Иргэд, албан хаагчдаас 8 хүсэлт ирсэн.



1 өргөдлийн хариуг газрын даргын 2025.01.14-ны өдрийн 11 тоот албан бичгээр шийдвэрлэж шуудангаар хүргүүлсэн.

Иргэд, албан хаагчдаас ирсэн 5 хүсэлтийг газрын даргын Б/02, Б/04, Б/05, Б/06, Б/08, Б/12 дугаартай тушаалуудаар шийдвэрлэсэн. Үлдсэн 2 хүсэлтийг тухайн үед нь шийдвэрлэж ажилласан. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног байна.

Сургалт, сурталчилгааны талаар

Тус газрын 2025 оны сургалтын төлөвлөгөөг 2025.02.25-ны өдөр баталж, албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх болон ажил олгогч, иргэд даатгуулагчдад мэдээлэл өгөх, нийгмийн даатгалын хуулийн танилцуулга, сургалт зохион байгуулж ажиллав. НДЕГ-аас Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор журам заавар, системийн шинэчлэл, санхүүгийн тайланг гаргах зааварчилгаа, архив албан хэрэг хөтлөлт, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн хэрэглээ гэх мэт 47 удаагийн цахим болон танхимын сургалтанд бүх албан хаагчид хамрагдсан.

Дүүрэгт үйл ажиллагаа эрхэлдэг Биеийн тамир спорт хороо, 207 дугаар цэцэрлэг, ЖДҮД төв, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Ус суваг ашиглалтын товчоо зэрэг 6 аж ахуй нэгж байгууллагын, 100 даатгуулагчдад нийгмийн даатгалын хуулийн сургалтыг хийж, танилцуулга мэдээлэл хүргэн ажилласан.



Дүүргийн Засаг даргын Тамгын газар болон бусад харьяалах 10 хэлтэс албадын мэргэжилтнүүдийн хамт “Түншлэл үйлчилгээний соёлыг дээшлүүлэх” зорилтот жилийн хүрээнд дүүргийн өртөө, зөрлөгийн шугам замын иргэд болон малчин, мал бүхий иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх “Иргэн таныг сонсьё” өдөрлөгийн хүрээнд тус газрын 3 албан хаагч иргэд, даатгуулагчдад Нийгмийн даатгалын тухай мэдээлэл өгч ажиллалаа. Тус өдөрлөгөөр

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

олгогчоор бүртгүүлэх тухай зэрэг нийгмийн даатгалын үйлчилгээтэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан.



Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэхээр 2 хорооны зорилтот бүлгийн иргэдэд хуулийн мэдээлэл өгч, сургалт зохион байгуулсан.



“Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах олон улсын өдөр”-ийг тохиолдуулан дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан арга хэмжээнд оролцож Сайн дурын нийгмийн даатгалын тухай хуулийн танилцуулга, мэдээлэл өгч 5 иргэний асуултад хариулт өгсөн байна.

Дүүргийн хөдөө аж ахуйн салбар болон малчдын зөвлөгөөнд “Сайн дурын нийгмийн даатгал ба ач холбогдол, малчны өндөр насны тэтгэвэр” сэдвээр мэдээлэл өгсөн.



Бусад аж ахуйн нэгж байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 29-ны өдөр Хөгжлийн менежмент сургалт судалгааны төвтэй хамтран байгууллагын удирдах албан тушаалтнуудад “Компаний засаглал”, “Төрийн албан хаагчийн



Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны талаар

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 7 дугаар тогтоол, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/130 дугаар тушаалын дагуу ХАБЭА-н сургалтыг зохион байгуулах байгууллагуудаас сонгон шалгаруулалт хийж “Ололт амжилт” сургалтын төвтэй хамтран 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдөр ажил олгогчдын ХАБЭА-н ажилтнуудад “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй”-н сургалтыг зохион байгуулсан бөгөөд уг сургалтад 28 ажил олгогчийн 39 ажилтан, албан хаагчид хамрагдсан.



Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах болон нэмэлт ажлын талаар:

Албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт тусгагдснаар газрын үйлчилгээний танхимын тохижилтын ажлыг хийж албан хаагчид ажиллах ая тухтай орчин бүрдүүлсэн.



Байгууллагын 1 албан хаагчийн хүүхдийн эмчилгээний зардалд 500.0мян төгрөг, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан 1 албан хаагчид 10.8 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Ахмадын тухай хууль, газрын даргын тушаалаар сар шинийн баяраар 4 ахмад настанд 800.0 мян төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.

Дүүргийн “Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх” зорилтот жилийн хүрээнд зохион байгуулсан “Оролцоод хөгжье” мэтгэлцээний тэмцээнд 1 албан хаагч оролцож дэд байр эзэлсэн амжилттай байна.



“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”, “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан албан хаагчдын гэр бүл, хүүхдүүдтэй хамтран уулзалт зохион байгуулж хүүхдүүдээ баярлуулсан.



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

Мөн ажилтан, албан хаагчдынхаа эрүүл мэндэд анхаарч, аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлж, эрт илрүүлгийн оношилгоонд хамруулан “Экспресс оношилгооны төв”-тэй хамтран ажилласан.


9 дүүргийн Нийгмийн даатгалын газрын албан хаагчдын дунд зохион байгуулсан спортын тэмцээнд 1 албан хаагч монгол бичгийн төрөлд, 1 албан хаагч дартсын төрөлд амжилттай оролцсон.



ТАЙЛАН БИЧСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ, АРХИВ, БИЧИГ
ХЭРГИЙН АЖИЛТАН

Н.НАНДИН-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:
ДАРГА



Б.БАЯРТУЯА